



MONGOLIAN NATIONAL
CLIMBING FEDERATION

ЦОЛ ЗЭРЭГ

2018 он

УУЛЫН СПОРТЫН ЦОЛ ЗЭРГИЙН ЖУРАМ

ӨНДӨР УУЛЫН АВИАЛТЫН ТӨРӨЛ

1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Олон улсын хэмжээний мастер горилогч уулчин нь спортын мастерын болзол хангасан байна.
- 1.2 Спортын мастер цолтой уулчин 8400 метрээс дээш өндөртэй оргилд 1 удаа, амжилтай авирч оргилд гаран авиралтаа баталгаажуулсан байна.
- 1.3 Хэт өндөр уулын авиралтын эрсдлийн багт ажиллах, аврах, зам тавих, хамгаалах үйл ажиллагааг бүрэн эзэмшсэн / тест, баримтаар хамгаална/.

2. Спортын мастер

- 2.1 Спортын мастер горилогч уулчин нь дэд мастерын болзол хангасан байна.
- 2.2 Алтай таван богд уулын Хүйтэний оргилд баталгаат авиралтын үндсэн 3 зам тус бүрээр авирч оргилд гарсан
- 2.3 Олон улсын авиралтанд оролцож 6000 метрээс дээш өндөртэй оргилд 1 удаа, 7000 метрээс дээш өндөртэй оргилд 1 удаа амжилттай авирч оргилд гаран авиралтаа баталгаажуулсан.
- 2.4 Техникийн, сонгомол замын авиралтуудыг 5-аас доошгүй удаа амжилттай хийж, аврах, хамгаалах, зам тавих арга ажиллагааг сурсан, уулын спортын онол, техникийг бүрэн эзэмшиж тестээр хамгаална. Өндөр уулын улсын аварга шалгаруулах тэмцээн /Альпинад /-д цол хамгаалах техникийн авиралтыг хийнэ.

3. Дэд мастер

- 3.1 Дотоод гадаадын 3800 м-ээс дээш өндөртэй 14 оргил тус бүрд амжилттай авирч оргилд гарсан. Өндөр уулын УАШ тэмцээн / Альпинад/-д 3 удаа оролцон техникийн авиралт хийсэн бол
- 3.2 Уулын спортын дадлага, онол, техникийн мэдлэгийг бүрэн эзэмшиж багаж хэрэгсэлтэй харьцан, олон улсын нэршлээр нэрлэж сурсан (тестээр хамгаална). Өндөр уулын улсын аварга шалгаруулах тэмцээн /Альпинад/-д цол хамгаалах техникийн авиралтыг хийнэ

4. Нэгдүгээр зэрэг

- 4.1 Далайн түвшнээс дээш 3800 м ба түүнээс дээш өндөртэй дотоод, гадаадын ууланд оргил давхцахгүй 10 удаа авирсан. Энэ авиралтын 2-оос доошгүй удаа нь Өндөр уулын авиралтын УАШТ /Альпиниад/-д амжилттай оролцож техникийн авиралт хийсэн байна.
- 4.2 Спорт авиралтын болон өндөр уулын авиралтын 1,2,3 дугаар түвшний сургалтанд хамрагдан шалгалт өгч тэнцсэн шүүгчийн тодорхойлолт, батламж байна.
- 4.3 Уулын спортын дадлага онол техникийн мэдлэгийг бүрэн эзэмшиж багаж хэрэгсэлтэй харьцаж олон улсын нэрээр нэрлэж сурсан байна./Тестээр хамгаална./

5. Хоёрдугаар зэрэг

- 5.1 Далайн түвшнээс дээш 3800 м түүнээс дээш өндөртэй дотоод, гадаадын ууланд оргил давхцахгүй 8 удаа авирсан. Энэ авиралтын 1-ээс доошгүй удаа нь Өндөр уулын авиралтын УАШТ /Альпиниад/-д амжилттай оролцсон байна.
- 5.2 Спорт авиралтын болон өндөр уулын авиралтын 1 ба 2 дугаар түвшний сургалтанд хамрагдан шалгалт өгч тэнцсэн шүүгчийн тодорхойлолт, батламж байна.
- 5.3 Уулын спортын дадлага онол техникийн мэдлэгийг бүрэн эзэмшиж багаж хэрэгсэлтэй харьцаж олон улсын нэрээр нэрлэж сурсан байна./Тестээр хамгаална./

6. Гуравдугаар зэрэг

- 6.1 Далайн түвшнээс дээш 3800 м түүнээс дээш өндөртэй дотоод, гадаадын ууланд оргил давхцахгүй 6 удаа авирсан байна.
- 6.2 Уулын спортын дадлага онол техникийн мэдлэгийг бүрэн эзэмшиж багаж хэрэгсэлтэй харьцаж олон улсын нэрээр нэрлэж сурсан байна./Тестээр хамгаална./

7. Улсын шүүгч

- 7.1 Улсын шүүгч нь тухайн спортын төрлөөрөө 10-аас доошгүй жил хичээллэж мэргэшсэн байх.
- 7.2 Улсын чанартай тэмцээнүүд тус бүр 10-аас доошгүй удаа ямар нэг маргаангүйгээр шүүсэн тухай шүүгчийн картанд тэмдэглэсэн байна.
- 7.3 Улсын чанартай шүүгчдийн сургалтад 3-аас доошгүй удаа хамрагдан шалгалт өгч тэнцсэн.
- 7.4 Авиралтын замын ангилалыг төрөл бүр дээр нь судалж, нэрлэж, зам тавьж, хамгаалалт хийж сурсан, аюулгүй ажиллагааны дүрмийг бүрэн эзэмшсэн. /7.4-ийг тестээр хамгаална/

1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, дэлхийн цом, тивийн наадамд медальт байр эзэлсэн.

2. Спортын мастер

2.1 Дэд мастер тамирчин нь тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, дэлхийн цом, тивийн наадамд шигшээ 16-д 1 удаа орсон.

2.2 Спорт авиралтын онол техникийг бүрэн эзэмшсэн.

3. Дэд мастер

3.1 Спорт авиралтын төрлүүдэд, Улаанбаатар хот, Улсын аварга шалгаруулах тэмцээн, Бүсийн аварга шалгаруулах тэмцээн, цомын тэмцээнд нийт 5 удаа медальт байранд шалгарч үүний 3 нь УАШТэмцээний алтан медаль байна.

3.2 Спорт авиралтын онол техникийг бүрэн эзэмшсэн.

4. Нэгдүгээр зэрэг

4.1 Спорт авиралтын төрлүүдэд Улаанбаатар хот, УАШТ, Бүсийн аварга шалгаруулах тэмцээн, Цомын тэмцээн тус бүрд оролцож нийт 4-өөс доошгүй удаа медальт байранд шалгарах, Үүнээс УАШ тэмцээний 1 алтан медаль байна.

4.2 Спорт авиралтын онол, техникийн мэдлэгийг бүрэн эзэмшиж, багаж хэрэгсэлтэй харьцаж сурсан байна.

5. Хоёрдугаар зэрэг

5.1 Спорт авиралтын төрлүүдэд Улаанбаатар хот, УАШТ, Бүсийн аварга шалгаруулах тэмцээн, Цомын тэмцээн тус бүрд оролцож нийт 3-аас доошгүй удаа медальт байранд шалгарах,

5.2 Спорт авиралтын онол, техникийн мэдлэгийг бүрэн эзэмшиж, багаж хэрэгсэлтэй харьцаж сурсан байна.

6. Гуравдугаар зэрэг

6.1 Спорт авиралтын төрлүүдэд Улаанбаатар хот, УАШТ, Бүсийн аварга шалгаруулах тэмцээн Цомын тэмцээн тус бүрд оролцож ,УАШ тэмцээнээс нэг удаа хагас шигшээд үлдэнэ.

6.2 Спорт авиралтын онол, техникийн мэдлэгийг бүрэн эзэмшиж, багаж хэрэгсэлтэй харьцаж сурсан байна